



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Концессын тухай хуулийн 2.4 дэх заалт, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар, Концессын “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжиж, Баянхонгор аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 3,931,002,323.00 (гурван тэрбум есөн зуун гучин нэгэн сая хоёр мянга гурван зуун хорин гурван) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянхонгор аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000048

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны .. 02 сарын .. 11-ний өдрийн
..31... дугаар тогтоолын хавсралт

**КОНЦЕССЫН БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ ТӨРЛӨӨР БАРЬСАН,
БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Байршил (сум, багийн нэр)	Барилга, байгууламж (хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ)-ийн нэр	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Баянхонгор	6 дугаар цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга	1,094,523,417.00
2	Баянхонгор /Баян-Ойт/	1 дүгээр цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга	1,136,088,741.00
3	Богд	Цэцэрлэгийн 50 ортой өргөтгөл	705,400,165.00
4	Баянхонгор /Шаргалжуут баг/	75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл	994,990,000.00
Нийт дүн			3,931,002,323.00
			(гурван тэрбум есөн зуун гучин нэгэн сая хоёр мянга гурван зуун хорин гурван)